



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**
Санхүүгийн аудитын алба

**Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн
2019 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

АУДИТЫН КОД: ДОА-2020/04/-ГА

Чойбалсан хот 2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn
Аудитор Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuub@audit.gov.mn
Аудитор Ж.Баяртуул
Утас: 7058-4207, Цахим хаяг: bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Дүрслэлийн товъёог	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4

БҮЛЭГ 1. ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ.

Аймгийн төсвийн нийи орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн ч хандив тусламжийн орлого нь тасарсан байна	5
--	---

БҮЛЭГ 2. ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ.

Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас хэтрүүлэн төлөвлөж, зарцуулсан байна.	7
---	---

БҮЛЭГ 3. ТЕЗ-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН ЗОРИЛТОТ ТҮВШИН.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 96.1 хувьтай байна.	11
--	----

ДҮГНЭЛТ:	14
----------------	----

ЗӨВЛӨМЖ:	15
----------------	----



Товчилсон үгийн тайлбар

ГА	Гүйцэтгэлийн аудит
ДОА	Дорнод аймаг
ҮАГ	Үндэсний аудитын газар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СС	Сангийн сайд
СХС	Сум хөгжүүлэх сан
ЗДТГ	Засаг Даргын тамгын газар
МУЗЗНДНТУТХ	Монгол улсын Засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЭМТ	Эрүүл мэндийн төв
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам



Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	“2016-2018 онуудын орлогын гүйцэтгэл, 2019 оны орлогын төлөвлөгөөний судалгаа”	5
График 2	“2019 оны орлогын төлөвлөгөө гүйцэтгэл”	5
График 3	“Сангийн яамны хянасан, ИТХ-аар баталсан төсвийн харьцуулалт”	8
Хүснэгт 1	“2019 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг харуулбал”	10
График 4	“Нэмэлт санхүүжилтийн орлогыг 2018 онтой харьцуулахад”	11



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дорнод аймгийн 2019 оны төсвийн гүйцэтгэлд 2019 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд хийв.
Аудитын зорилт	Орон нутгийн 2019 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • 2019 оны төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл • 2019 оны төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл • ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшин
Аудитын хамарсан хүрээ	Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу орон нутгийн 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг дараах бүрэлдэхүүн хэсэг, дараалалтай тайлагнажээ. Үүнд: • Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, • Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл; • Нэмэлт төсвийн гүйцэтгэл, • Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн,
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, Аудитын олон улсын стандарт, Гүйцэтгэлийн аудитын арга зүй, журмыг баримтлан гүйцэтгэсэн бөгөөд аймгийн ерөнхий нягтлан бодогч, төсвийн ахлах мэргэжилтэнтэй ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, санхүүгийн аудитын албаны ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Одхүү, Ж.Баяртуул нар хийж гүйцэтгэлээ. Аудитын талбарын ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлж, тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ҮАГ-ын Санхүүгийн аудитын газар болон аймгийн Засаг даргад 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлээ.

1. ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

Аймгийн төсвийн орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн боловч хандив тусламжийн орлого тасарсан байна.

Төсвийн тухай хуулийн 31.1.3-т зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан.

Төсвийн тухай хуулийн 4.1.8-д зааснаар жилийн төсвийн хязгаар нь орлогын доод, зарлагын дээд хэмжээ бөгөөд Сангийн яам 2019 оны төсвийн жилийн суурь орлогыг 17.3 тэрбум төгрөгөөр хянасныг, төсвийн төсөлд 20.5 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна.

Аймгийн 2019 оны төсвийн нийт орлогыг 24.128,6 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2016-2018 оны орлогын гүйцэтгэлүүдээс 3.616,5-7.046,8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

График №1. “2016-2018 онуудын орлогын гүйцэтгэл, 2019 оны орлогын төлөвлөгөөний судалгаа” /төгрөг/



Аймгийн 2019 оны төсвийн нийт орлого 25.937,5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөгөөнөөс 7.5 хувь буюу 1.808,9 сая төгрөгөөр давж биелсэн байна.

График №2. “2019 оны орлогын төлөвлөгөө гүйцэтгэл” /төгрөг/



Нийт орлогын биелэлтэд татварын орлогын төлөвлөгөө 7.4 хувиар буюу 1,938.2 сая төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байгаа бөгөөд татварын бус орлогын гүйцэтгэл 2 хувь буюу 129.2 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл дараах байдалтай байна.

1.Татварын орлогын талаар:

1.1 Дараах орлогуудыг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

- **Хувь хүний орлогын албан татварыг** өмнөх оны гүйцэтгэлээс 196.2 сая төгрөг буюу 2.0 хувиар нэмэгдүүлэн төлөвлөснийг татвар төлөгчдийн тооны дундаж өсөлтийн хувь хэмжээтэй харьцуулахад үндэслэлтэй байна. Гүйцэтгэл нь 931.4 сая төгрөг буюу 8.9 хувиар өссөн нь 2019 онд гарсан ЗГ-ын тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг 8 хувиар нэмсэнтэй холбоотой байна.
- **Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг** өмнөх оны гүйцэтгэлээс 10.6 сая төгрөг буюу 1.8 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн нь 2018 оны эцсийн байдлаарх үл хөдлөх хөрөнгийн талаарх Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээлэлд үндэслэсэн байна. Гүйцэтгэлээр 38.3 сая төгрөг буюу 6.2 хувиар давж биелсэн нь тайлант оны үл хөдлөх хөрөнгийн бага хэмжээний өсөлтөөс шалтгаалсан байна.
- **Авто тээврийн хэрэгслийн албан татварыг** өмнөх оны гүйцэтгэлээр төлөвлөсөн нь 13.1 сая төгрөг буюу 3.5 хувиар давж биелсэн нь тайлант онд авто тээврийн хэрэгслийн тоо 1.2 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байгаа бөгөөд энэ өсөлтийг урьдчилан төлөвлөх боломжгүй байна.
- **Ус рашааны нөөц ашигласны төлбөрийг** 3,928.8 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 291.2 сая төгрөг буюу 8.0 хувиар өссөн байна. Энэ нь өмнөх онд үйл ажиллагаа нь түр хугацаанд зогссон уул уурхайн компаниуд тайлант онд хэвийн ажиллана гэж тооцсонтой холбоотой байгаа бөгөөд гүйцэтгэлээр 100.05 хувьтай биелсэн байна.
- **Ойн нөөц ашигласны төлбөрийг** өмнөх оны гүйцэтгэлээс 14.4 сая төгрөг буюу 40.3 хувиар нэмэгдүүлсэн нь БОАЖЯ-наас өгсөн зөвшөөрлийн хэмжээгээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 3.1 сая төгрөг буюу 6.2 хувиар давж биелсэн нь уг зөвшөөрлөөс гадна ойн цэвэрлэгээ хийсэнтэй холбоотой байна.
- **Газрын дуудлага худалдааны орлого нь** өмнөх оны гүйцэтгэлийн түвшинг үндэслэн төлөвлөх боломжгүй орлого бөгөөд тайлант онд дуудлага худалдаанд оруулахаар төлөвлөсөн газрын байршил болон оролцогчийн тоо хэмжээ гэх мэт тооцоолох боломжгүй олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Тус орлогыг тайлант оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан 275.6 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оноос 45.6 сая төгрөгөөр илүү байна. Гүйцэтгэлээр нийт 77 байршилд зарлагдсан дуудлага худалдаанаас 36 дуудлага худалдаа амжилттай болж, орлого 298.4 сая төгрөг буюу 108.3 хувиар давж биелсэн байна.

1.1 Дараах орлогуудыг үндэслэлгүй төлөвлөсөн байна.

- **Галт зэвсгийн албан татварын орлогын төлөвлөгөө** 2016-2018 онуудад байнга тасарч байсан бөгөөд 2019 онд өмнөх оны гүйцэтгэлээс 2,4 сая төгрөг буюу 5.3 хувиар бууруулж төлөвлөсөн нь гүйцэтгэлээр 37.6 сая төгрөг буюу 9.5 хувиар тасарсан байна. Энэ нь цагдаагийн газарт бүртгэлтэй галт зэвсгийн мэдээлэл болон татварын хэлтэс дэх мэдээллийн зөрүүтэй байдлаас шалтгаалсан байна.
- Аймгийн хэмжээнд Хэрлэн сум нь **улсын тэмдэгтийн хураамжийг** орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 23.4.9 дэх заалттай нийцэхгүй байгаа бөгөөд Төрийн аудитын байгууллагаас 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтэд болон 2018 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитуудаар уг асуудлын талаар зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байгаа тул УАГ-т уламжилж МУ-ын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгуулах саналтай байна. Хэрлэн сум нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнд зөвшөөрөл, виз олгохтой холбоотой улсын тэмдэгтийн хураамжаас 2019 онд 796.5 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн нь 750.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

- **Газрын төлбөрийн орлогыг** өмнөх оны гүйцэтгэлээс 35.3 сая төгрөг буюу 7.3 хувиар бууруулан төлөвлөсөн нь гүйцэтгэлээр 631.4 сая төгрөг буюу 40.3 хувиар давж биелсэн байна. Энэ нь 2018 оны Засгийн газрын 182 дугаар тогтоолоор газрын төлбөрийн суурь үнэлгээг нэмэгдүүлсэн байхад нэмэгдлийг тооцон төлөвлөөгүйтэй холбоотой байна.
- **Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны татварын орлогыг** өмнөх оны гүйцэтгэлээс 9.2 сая төгрөг буюу 9.2 хувиар бууруулан төлөвлөсөн нь Халхгол сумын газрын тосны 19 дүгээр талбайд үйл ажиллагаа явуулж байсан “Арж капитал” ХХК-ийн замын ажил дууссантай холбоотой байна. Гүйцэтгэлээр 37.8 сая төгрөг буюу 41.5 хувиар тасарсан нь төлөвлөлтийн үед тооцоо судалгааг бүрэн хийгээгүйтэй холбоотой байна. Тайлант онд орон нутагт хийгдэх авто замын ажлууд бүрэн хийгдээгүй, мянганы замын өргөрөгтэй давхацсан 21 дүгээр талбайн замын ажилд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмал нь татвараас чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор орлого тасарсан байна.

2. Татварын бус орлогын талаар:

Татварын бус орлого нь 5 нэр төрлийн орлогоос бүрдэж байна. Нийт 6,464.7 сая төгрөгийн орлогын 65 хувь буюу 4,233.5 сая төгрөгийг хандив, тусламжийн орлого эзэлж байна.

Орлогуудыг нэр төрөл бүрээр авч үзвэл дараах байдалтай байна.

- Хүүгийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлийн түвшинд төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 178.5 сая төгрөг буюу 21.9 хувиар давж биелсэн иргэдийн арилжааны банкн дахь хадгаламжийн хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалсан байна.
- Торгуулийн орлого нь тодорхойлох боломжгүй орлого тул өмнөх оны гүйцэтгэлийн түвшинг үндэслэн төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 706.4 сая төгрөг 63.1 хувь буюу 63.1 хувиар давж биелсэн байна.
- Бусад татвар буюу нэр заагдаагүй татварын орлого нь урьдчилан тооцох боломжгүй орлого тул өмнөх оны гүйцэтгэлийн түвшинд төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 104.5 сая төгрөг буюу 35.5 хувиар давж биелсэн байна.
- Тусламжийн орлогыг тайлант онд уул уурхай эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 20 аж ахуйн нэгжээс нийт 4.233,5 сая төгрөгийн хандив авахаар төлөвлөсөн боловч нийт 1.115,2 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. Үүнээс: албан ёсоор байгуулсан гэрээ хэлцэлгүй 4 компанийн 252.5 сая төгрөг, зөвшөөрлийн хугацаа дууссан 1 компанийн 15.0 сая төгрөг, гэрээ хийгдсэн боловч дутуу төвлөрүүлсэн 5 компани 899.1 сая төгрөгийн орлого байна. Харин гэрээний дагуу хандивыг 2 компани 51.5 сая төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

Төрийн аудитын газраас “Аймгийн 2019 оны орон нутгийн төсөв”-ийн төсөлд эх үүсвэр тодорхойгүй, гэрээ хэлцэл бүрэн хийгдээгүй хандивын орлогыг 3.1 тэрбум төгрөгөөр бууруулах тухай саналыг өгсөн ч аймгийн ИТХ-аар хандивын орлогыг 4.2 тэрбум төгрөг хэвээр байхаар баталснаас тус орлого 1.2 тэрбум төгрөг буюу 26.3 хувиар тасарсан байна.

2. ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ ГҮЙЦЭТГЭЛ

Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас хэтрүүлэн төлөвлөж, зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 4.1.30-д зааснаар орон нутгийн төсвийн суурь зарлага нь орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбоотой урсгал болон хөрөнгийн зардал, дараах бусад чиг үүргүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал зардлуудын нийлбэрээр тодорхойлогдож байна. Үүнд:

- Нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх
- Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалт




- Соёлын үйлчилгээ
- Нийтийн биеийн тамир

Сангийн яам нь 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдөр аймгийн 2019 оны төсвийн суурь зарлагын хязгаарыг 12.6 тэрбум төгрөгөөр баталж, 2018 оны 11 дүгээр сарын 23-нд эцсийн байдлаар хянаж ирүүлэхдээ 14.9 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн суурь зардлыг Сангийн яамны хянасан дүнгээс 1,957.4 сая төгрөгөөр хэтрүүлэн төлөвлөж батлуулсан байна. Төрийн аудитын газраас ТЕЗ-ийн төсвийн төсөлд хязгаарыг баримтлах талаар санал өгч байсан.

Аймгийн ИТХ-аар батлагдсан 2019 оны төсөв болон Сангийн яамны хянасан дүнг харьцуулж харуулбал:

График №3. “Сангийн яамны хянасан, ИТХ-аар баталсан төсвийн харьцуулалт”
/сая.төг/



Дээрх графикаас харахад хязгаараас 3 төрлийн багц зардал хэтэрсэн байна.

1.Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын өсөлт нь дараах шалтгаантай байна.

1.1. Аймгийн ИТХ, аймаг, сумдын ЗДТГ, Санхүү хяналт аудитын алба, Орон нутгийн өмчийн албаны батлагдсан орон тоо Сангийн яамны хянасан дүнгээс нэмэгдсэн байна.

Орон тоог хязгаараас нэмэгдүүлж баталдаг асуудал урд онуудад мөн гарч байсныг төсвийн төсөлд өгсөн саналуудад жил бүр тусгаж байсан. Энэ нь орон нутаг төсвөө хязгаарт багтаах тухай хуулийн заалтад нийцүүлэн боловсруулахгүй байгаатай холбоотой ч, Сангийн яам орон тоог бодит нөхцөл байдалтай уялдуулан тооцохгүй байгаа нь мөн нөлөөлсөн байна. Тухайлбал:



- Аймгийн ИТХ нь МУЗЗНДНТУТХ-ын 20.3-т “Хурлын Тэргүүлэгчид ажлын албатай байх бөгөөд түүний орон тоо, цалингийн санг Төсвийн тухай хуулийн 10.1.2-т заасан тухайн жилийн төсвийн хязгаарт багтаан Тэргүүлэгчид өөрөө тогтооно.” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.
- Сангийн яам нь ЗДТГ-уудын орон тоог ЗГ-ын тогтоолд заасан орон тоогоор баталж, нийтлэг үйлчилгээний албан хаагчдыг оруулан тооцдоггүй байна.
- Санхүү хяналт аудитын албаны орон тоо нь Мэргэжлийн хяналтын газраас шилжин ирсэн улсын байцаагчид болон бусад зайлшгүй байх үйлчилгээний албан хаагчдаас бүрдэж байна. Орон нутгийн өмчийн газарт бүтцийн өөрчлөлтөөр нэгдэхээс өмнөх Орон нутгийн өмчийн албаны 3, Худалдан авах ажиллагааны албаны 6 орон тооноос нэмэгдсэн орон тоо байхгүй байна.

1.2. Аймгийн ИТХ, Хэрлэн сумын ИТХ-ын төсөв нь намын суудлын мөнгөөр нэмэгдсэн байна.

- Орон нутгийн төсвөөс аймгийн ИТХ-д суудалтай намуудад 2019 онд 68.0 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын 2012 оны 2 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолыг үндэслэн олгосон байна. Уг тогтоолыг Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18,19 дүгээр заалт, улс төрийн намуудын бүлгийн саналыг үндэслэн гаргасан байна. Орон нутгийн ИТХ-д суудалтай намд санхүүгийн дэмжлэг олгох ямар нэгэн хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

1.3. ТЕЗ нь сангийн яамны хянасан дүнд тусгагдаагүй сумдын орон нутгийн нөөц хөрөнгийн зардлыг нэмж батлуулсан байна.

- Хууль, тогтоомжийн дагуу сумдын төсвийн бүрэлдэхүүнд Засаг даргын нөөцийн сангийн хөрөнгө байх ёстой бөгөөд төсвийн төслийн саналд тусган Сангийн яаманд хүргүүлдэг ч хянахдаа хасаж ирүүлдэг байна.

2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал нэмэгдсэн нь хот тохижилтын зардлын дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

- “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ нь аймгийн төвд байгаа айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад хог тээвэрлэлтийн үйлчилгээг үзүүлдэг бөгөөд аймгийн төсвөөс 569.0 сая төгрөгийн санхүүжилт авч, хогны хураамжийн орлого 280,0 сая төгрөгийг Хэрлэн сумын төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь төсвийн удирдамжид заасан “Хот тохижилтын асуудал хариуцсан байгууллагыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулан, үйлчилгээний хураамжийг бодитой тогтоож, хураамжийн орлогоо зарцуулах эрхийг олгож, менежментээ өөрсдөө хариуцдаг тогтолцоонд шилжүүлэх” гэсэн чиглэлд нийцэхгүй байна.

Төрийн аудитын газраас 2019 оны төсвийн төсөлд дээрх асуудлын талаар санал өгсөн ч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3. Соёл, спортын байгууллагуудын зардлын дүн нэмэгдсэн нь барилга байгууламжийн ашиглалтын зардлын дүнгийн бууралттай холбоотой байна.

- Дээрх байгууллагуудын төсвийг орон нутагт шилжүүлснээр, барилга байгууламжийн ашиглалтын зардлын дүнд багтаж байсан тогтмол зардлууд нь Соёл, спортын байгууллагуудын зардлын ангилалд шилжсэн байна.

Сангийн яам төсвийн хязгаарыг хянахдаа сумдын нөөц хөрөнгө болон байгууллагуудын орон тоог улсын хэмжээн дэх жишиг үзүүлэлтийг харгалзан бодитой тооцох талаар ҮАГ-т уламжилж, МУ-ын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгуулах саналтай байна.

Аймгийн төсвийн нийт зарлага 66,164.8 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс жилийн эцсийн байдлаар 95.1 хувь буюу 62,903.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 50,735.6 сая төгрөг буюу 80.7 хувийг урсгал зардалд, 11,036.8 сая төгрөг буюу 17.5 хувийг хөрөнгийн зардалд, 1,131.2 сая төгрөг буюу 1.8 хувийг эргэн төлөгдөх зээл олголтод зарцуулсан байна. Үүнээс:

- Орон нутгийн төсвийн нийт зарлага 34,274.5 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 31,084.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардалд 31,890.3 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 31,819.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №1. “2019 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн зарцуулаагүй үлдэгдлийг харуулбал:”
/сая.төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	66 164,8	62 903,6	3 261,2	95,1
УРСГАЛ ЗАРДАЛ	51 661,9	50 735,6	926,3	98,2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49 226,9	48 318,0	908,9	98,1
ТАТААС	891,0	891,0	-	100,0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1 544,0	1 526,6	17,4	98,9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12 837,9	11 036,8	1 801,1	86,0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ	1 665,0	1 131,2	533,8	67,9

Нийт гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйд хөрөнгийн зардал 86.0 хувьтай зарцуулагдаж, эргэн төлөгдөх зээл 67.9 хувьтай олгогдсон нь нөлөөлсөн байна. Энэ нь хандив тусламжийн эх үүсвэрийн санхүүжилт дутуу төвлөрч, СХС-гийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байсантай холбоотой байна.

Урсгал зардлын хувьд 1.8 хувийн хэмнэлттэй харагдаж байгаа ч энэ нь Төсвийн тухай хуульд заасан бодит хэмнэлтэд хамаарахгүй байна.


Учир нь сумдын ЭМТ 51.5 сая төгрөг, СӨБ-өөс 8.3 сая төгрөг, ЕБС-иас 10.0 сая төгрөг ГХБХБГ-аас 1.2 сая төгрөг, ГБХЗХГ-аас 0.3 сая төгрөг, нийт 71.3 сая төгрөгийг зарцуулаагүй байгаа нь СӨБ, ЕБС-ийн боловсон хүчин дутагдалтай байгаагаас орон тоо дутуу ажилласан, шинэ барилгууд хугацаандаа ашиглалтад ороогүйгээс төлөвлөсөн зардлууд бүрэн зарцуулагдаагүйтэй холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад харьяалагдах төсвийн байгууллагуудын нэмэлт орлогын дансанд 4,340.8 сая төгрөгийн орлого дараах эх үүсвэрүүдээс орсон байна. Үүнд:

- ✓ Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 284.3 сая төгрөг,
- ✓ Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс 3,498.6 сая төгрөг
- ✓ Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 526.3 сая төгрөг,
- ✓ Улсын хэмжээнд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн санхүүжилтээс 31,6 сая төгрөг.

Тайлант онд ТЕЗ-ийн эрхлэх хүрээний байгууллагууд 4,340.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтээс 4,177.3 сая төгрөгийг зарцуулж 163.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

График №4. “Нэмэлт санхүүжилтийн орлогыг 2018 онтой харьцуулахад.”
/сая төгрөг/



Өнгөрсөн онд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.3, Төсвийн тухай хуулийн 25.2 дахь заалтуудыг зөрчин хандив авах эрхгүй, дээд шатны төсөв захирагчаас зөвшөөрөл аваагүй хандив, тусламж авсан зөрчлүүд гарч байсан боловч энэ онд дээрх зөрчил давтагдаагүй байна.

3. ТЕЗ-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШИН

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 96.1 хувьтай байна.

ТЕЗ нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн, орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнг төлөвлөн батлуулсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт хамрагдах 24 төсөл арга хэмжээ батлагдсанаас орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны 1 хөтөлбөрт хамаарах 3 арга хэмжээ, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт хамаарах орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлэх 14, улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх 7 арга хэмжээ байна.

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр арга хэмжээнүүдэд орон нутгийн төсөвт байгууллагууд болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ахмад настны хөгжил хамгаалал, нийгмийн халамж, мал эмнэлгийн үйлчилгээ, хот тохижилт, авто замын сан, мал хамгаалах сан, орон нутгийн төсвийн болон

хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээтэй холбоотой үйл ажиллагаанууд байна.

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсэгт “Төсвийн байгууллагын төсвийн шууд захирагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг харьяа байгууллагын үйл ажиллагааны үр дүнгээр үнэлнэ.” гэж заасны дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь ТЭЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрт хамаарах орон нутгийн ТШЗ-дын байгууллагуудын ажлын биелэлтийг дүгнэн 81.4-100 хувьтай дүгнэсэн байна. Эдгээр төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар, хэрэгжүүлэх хөтөлбөр нь зорилтот үр дүндээ хүрээгүй ТШЗ байгаагүй тул дээрх үнэлгээ нь үндэслэлтэй байна.

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах бусад хөтөлбөр, арга хэмжээнүүдээс 337.4 сая төгрөгийн доорх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Үүнд:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- “Хавирга”-ын хилийн боомтын авто замыг орц гарц бүхий урсгалтай болгох – 30.0 сая төгрөг

Замын сангийн хөрөнгө:

- Халхгол сумын хөшөө, дурсгалын хоорондох автозамын засвар – 32.0 сая төгрөг

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө:

Аймгийн орон нутгийн хөгжлийн сан

- Чулуунхороот сумын төвийн ЦДАШ-ын өргөтгөл – 10.0 сая төгрөг
- Хэрлэн сумын хүүхдийн цэцэрлэгийн салбар байгуулах дэмжлэгт - 20.0 сая төгрөг

Сумдын орон нутгийн хөгжлийн сан

- Дашбалбар сумын “хүүхдийн тоглоомын талбай”, “бохирын машины гарааж барих”, “буриад омгийн хонины суурь бүрдүүлэх” 3 төсөл арга хэмжээ - 54.5 сая төгрөг
- Сэргэлэн сумын “нэгдсэн хогийн цэгийг тохижуулах радиусыг багасгах”, “нийтийн эзэмшлийн гудамж талбайд засвар үйлчилгээ хийх”, “мод тарих”, “нийтийн ахуй үйлчилгээний байр барих”, “нийтийн халууны усны тохижилт сайжруулах” 5 төсөл, арга хэмжээ - 40.0 сая төгрөг
- Хөлөнбуйр сумын “Соёлын төвийн дээврийн засвар”, “шинээр худаг гаргах” 2 төсөл арга хэмжээ - 30.0 сая төгрөг
- Хэрлэн сумын “7 дугаар цэцэрлэгийн хойд талд авто машины зогсоол барих”, “ахмадын чөлөөт цагийн байр байгуулах” 2 төсөл арга хэмжээ – 20.0 сая төгрөг
- Цагаан-Овоо сумын “сумын нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө”, “ундны худгийн барилгын засвар хийх” 2 төсөл арга хэмжээ - 58.9 сая төгрөг
- Чойбалсан сумын “Багийн төвд хүүхдийн тоглоомын талбай, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж /Жишиг хороолол/, “Гудамжны гэрэлтүүлэг шинээр тавих”, “Хөдөөгийн багуудад гүний худгийн цооног гаргах”, “Сумын төвийн нэгдсэн халаалт, цэвэр бохир усны нэгдсэн байгууламжийн зураг төсөв хийлгэх”, “Бод малын хашаа барих” 5 төсөл арга хэмжээ - 72.0 сая төгрөг

Нийт хөтөлбөр, арга хэмжээний 3.9 хувь бүрэн хэрэгжээгүй нь төсвийн орлогыг баталгаагүй эх үүсвэрээр төлөвлөсөнтэй холбоотой бөгөөд Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7 дахь хэсэгт “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэж заасантай нийцэхгүй байна.



Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр арга хэмжээнүүд нь СӨБ, ЕБС, соёл, эрүүл мэндийн анхан шатны тусламж, газрын харилцаа, барилга хот байгуулалт, хүүхдийн хөгжил хамгаалал, нийтийн биеийн тамир спортын үйлчилгээний үйл ажиллагаатай холбоотой байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын үйл ажиллагааг “Ковид19” вирус тархсантай холбоотойгоор бүрэн дүгнээгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар эдгээр байгууллагуудтай холбоотой санхүүжилтийг бүрэн аваагүй, гүйцэтгэл зорилтот үр дүндээ хүрээгүй байгаа талаар асуудал илрээгүй.

ТЕЗ-ийн төсөвт хамаарах нийгмийн салбарын хүрээнд батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилт, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх ажлуудын явцад аймгийн ИТХ-ын 2019 оны 68 дугаар тогтоолоор байгуулагдсан, аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан бодлогын хороодын дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт тавьж ажилласан байна. Ажлын хэсгийн тайланг ИТХ-аар хэлэлцүүлсэн ч үр дүнг сайжруулах талаар зохион байгуулсан ажил нь тодорхойгүй байна.

Мөн Дорнод аймагт төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд иргэдийн хяналт тавих нөхцөлийг хангах зорилгоор <http://report.dornod.gov.mn/> цахим системийг хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2018 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн зөвлөмж өгч ажилласан ч 2019 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна. Иймд эрсдэлийг бууруулах зорилгоор ТЕЗ-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

ТЕЗ-ын орон нутгийн хөрөнгө оруулалт, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ, орон нутгийн хөгжлийн сангийн нийт 4,971.6 сая төгрөгийн зарцуулалтын гүйлгээнд ТЕЗ болон аймгийн ерөнхий нягтлан бодогч нар 1, 2 дугаар гарын үсэг зуран зарцуулж байгаа нь хяналтын тогтолцоо алдагдах эрсдэлтэй байна.

СС-ын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.3 дахь хэсэгт *“Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэлийн үйл ажиллагаа, үр дүнг хариуцаж ажиллана”* гэж заасан байна.

Мөн Төрийн аудитын газар нь 2020 оны төсвийн төсөлд “байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгийн зарцуулахдаа ТШЗ-ийн үүргийг ТЕЗ хэрэгжүүлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан ТЕЗ-ийн бүрэн эрхэд нийцэхгүй байгаа” талаар санал өгсөн. Иймд дээрх заалтыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

**ДҮГНЭЛТ:**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн ч хандив тусламжийн орлого нь тасарсан байна.
2. Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас хэтрүүлэн төлөвлөж, зарцуулсан байна.
3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 96.1 хувьтай байна.

Аудитаар нийт 3,072.5 сая төгрөгийн зөрчилд илэрсэнд 2 санал, 3 зөвлөмж өгч ажиллалаа.

Санал:**Үндэсний аудитын газарт:**

МУ-ын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дараах асуудлуудыг тусгуулах саналтай байна.

1. Улсын төсөвт төвлөрүүлэх тэмдэгтийн хураамжийн орлогыг сумын төсвийн бүрэлдэхүүнд оруулан төлөвлөн зарцуулж байгааг Төсвийн тухай хуулийн 23.4.9 дэх заалттай нийцүүлэх талаар Сангийн яаманд уламжлах.
2. Төсвийн хязгаарыг хянахдаа сумдын нөөц хөрөнгө болон төсөвт байгууллагуудын орон тоог улсын хэмжээн дэх жишиг үзүүлэлтийг харгалзан бодитой тооцох талаар Сангийн яаманд уламжлах.



ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд зөвлөж байна.

1. Төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, биелэлтийг ханган ажиллах.
2. Төсвийг хязгаарт багтаах Төсвийн тухай хуулийн заалтыг мөрдөж ажиллах.
3. ТЕЗ-ийн хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтын үр дүнг сайжруулах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2020 оны 12 дүгээр сарын 05-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.